



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/08

Бөхт

Эрүүл мэндийн төвийн бүтэц орон тоог
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн 2024 оны бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.
2. Манлайлах ур чадвараа дээшлүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хариуцлагатай, идэвх санаачилгатай хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.


ДАРГА



У.АЛТАНХҮҮ

1124010025

Сумын Засаг даргын 2024 оны 01дүгээр сарын 18ны
өдрийн А/08 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БҮТЭЦ ОРОН ТОО

Д/д	Ажлын байрны нэр	Ажил эрхлэгчийн тоо	Хариуцах чиг үүрэг
1	Дарга	1	Сумын хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулна. Эрүүл мэндийн төвийн боловсон хүчний хангалт, ажилчдын ажлын байрны сургалт, нийгмийн асуудал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга барилд сургах, зөв дадал хэвшил тогтоох, хүн амын өвчлөлд дүгнэлт судалгаа хийж нөлөөлөх хүчин зүйлийг бууруулах ажлыг удирдлага арга зүйгээр хангана. ЭМЯ, ЭМГ- аас зохион байгуулж байгаа багц цагийн сургалтуудад мэргэжилтнүүдийг бүрэн хамруулах
2	Эмчлэгч эмч	1	Хүн амын халдварт ба халдварт бус өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх, яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж үйлчлэх ажилчдад эрэмбэлэн ангилалтын дагуу үйлчилгээ үзүүлэх арга барилыг эзэмшүүлэх, эмийн ба эмийн бус эмчилгээг хавсруулан гүйцэтгэх ажлыг зохион байгуулна
3	Багийн эмч	3	Багийн хүн амыг бүртгэлжүүлэх судалгаа гаргах, төв хөдөөгийн дуудлаганд цаг алдалгүй явах, дархлаажуулалтанд хамруулах эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл идэвхтэй хяналтыг тогтоох, шатлалын эмнэлэгт илгээх, групп тогтоолгох, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх нөхөн сэргээх тусламж үйлчилгээнд хамруулах ажлыг гүйцэтгэнэ
4	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	1	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт суртөлчилгаа хийж зөв дадал хэвшил тогтоох ажлыг зохион байгуулж ажиллана.
5	Эх баригч бага эмч	1	Төрөх насны эмэгтэйчүүдийн судалгаа гаргаж гэр бүл төлөвлөлтийг зохицуулах, жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналтын үзлэг хийх шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт

			оруулах, төрөх өрөөний тохижилтыг сайжруулж бэлэн байдлыг хангах, 0-5 насны хүүхдийн дархлаажуулалтын ажлыг хариуцан гүйцэтгэнэ. Малчин өрхийн жирэмсэн эмэгтэйчүүдийг товлолын үзлэг шинжилгээнд хамруулах, төрөлтийн төлөвлөгөө боловсруулах, сургалт зохион байгуулах. Төрөхийн өмнөх эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.
6	Дүн бүртгэгч бага эмч	1	ЭМГ- аас авч байгаа мэдээ тайланг хугацаанд нь гаргаж өгөх. Сумын хүн амыг эрүүл мэндийн бүлгээр ангилах тайлагнах. Анхан шатны маягтын бүртгэл хөтлөлтөнд хяналт тавьж хугацаанд нь архивлаж хадгалах, тушаал зааваруудыг мөрдөж ажиллах хариутай бичгийг хугацаанд өгөх ажлыг зохион байгуулна Шилэн дансанд байгууллагын хийсэн ажил хүний нөөцийн шинэчлэл, худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлын байршуулна.
7	Ахлах сувилагч	1	Сувилахуйн тусламж үйлчилгээний ажлыг хариуцаж сувилагч нарын мэдлэг боловсролыг дээшлүүлж, сувилахуйн бэлэн байдлыг хангаж, яаралтай тусламжийн эм тариаг тушаал зааварын дагуу бэлэн байлгаж зарцуулалт болон хугацаанд хяналт тавьж ажиллана. Сувилагч нарт ижил мэргэжилтний үнэлгээ хийнэ. Хөтлөгдвөл зохих анхан шатны маягтыг хөтөлж хүлээлцэх ажлыг хариуцана.
8	Сувилагч	4	Үйлчлүүлэгчдэд сувилахуйн тусламж үйлчилгээг хүргэж эм тарианы зарцуулалтыг цаг тухайд нь гаргана. Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгоно
9	Лаборант	1	Сумын эмнэлгийн лабораторийн бэлэн байдлыг хангаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана. Суманд хийгдэх шинжилгээг бүрэн хийж оношлогоо эмчилгээний чадавхыг сайжруулна

10	Ариутгагч	1	Ариутгалын тоног төхөөрөмжийн ажиллах заавар болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөнө. Боолтын материал, багаж хэрэгслийг шаардлагатай тохиолдол бүрт ариутгаж сувилагч нарт хүлээлцэнэ
11	Жолооч	1	Түргэн тусламжийн машины бэлэн байдлыг хангаж яаралтай тусламжийн дуудлаганд цаг алдалгүй явж үйлчилнэ. Автомашиныг ариг гамтай эзэмшиж урсгал засварыг цаг тухайд нь хийнэ. Байгууллагын шаардлагаар аймаг, сум явах өвчтөн хүргэх, сургалт семинарт оролцох болон өдөр тутмын нийтлэг ажил хийж гүйцэтгэх / ус авах, хог аснах гэх мэт /
12	Тогооч	1	Хэвтэн эмчлүүлж буй өвчтөнд эмчилгээний хоолоор үйлчлэх, хоолны технологийг мөрдөн ажиллаж хөтлөгдвөл зохих анхан шатны маягтыг хөтлөх. Бэлэн болсон хоолонд амтлагаа хийлгэж маягт хөтлөж устгал хийж протокол хөтөлнө. Өдөр бүр өвчтний тоонд тохируулан хоолны материалыг авч хоол үйлдвэрлэлтийг явуулна
13	Үйлчлэгч	2	Эмнэлгийн цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг цаг тухайд нь чанартай хийж гүйцэтгэнэ. Ариутгалын бодисоор халдваргүйтгэл хийж иргэдийг цэвэр орчинд тусламж үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Эмнэлгийн гадна орчинг цэвэр үзэмжтэй байлгах. Хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зөвлөмж өгч эргэлтийг хугацаанд оруулж угтах үйлчилгээний ажлыг гүйцэтгэнэ.
14	Нягтлан бодогч	1	Байгууллагын төсвийн орлого зарлага зарцуулалтын мэдээг тухай бүрт гарган тайлагнаж байгууллагын төсвийн зарцуулалтад байгууллагын удирдлагатай хамтран ажиллах

15	Нярав	1	Бараа материалыг татан авах, түүнийг хамгаалах Хүнсний агуулахын дотоод зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт хяналт тавьж эмх цэгцтэй байлгах Эд аж ахуйн бүртгэл тайлан тооцоог хугацаанд хийж тайлагнах, Эд ахуйд засвар үйлчилгээ хийх Хүнсний болон бичиг хэрэг, угаалгын материалыг шаардах хуудасны дагуу олгох Эд хөрөнгө хариуцагчийн картын хөтөлж эвдрэлийг цаг хугацаанд нь засварлуулж, шаардлагатай бол нөхөн төлүүлж, эдэлгээний хугацааг уртасгах Хэрэггүй болсон эд зүйлсийг зохих журмын дагуу актлах
16	Эмийн санч	1	Эм тариа татан авах, түүнийг хамгаалах эмийн агуулахын дотоод зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт хяналт тавьж эмх цэгцтэй байлгах Сумын иргэдийн эм тариаг ханган ажиллах